

ЗОРИГТ ВАНГИЙН “ҮЗЭГСДИЙН БАЯСГАЛАН” СУДАР ДАХЬ ХЯТАД ГАРАЛТАЙ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, ЖОРЫН ТҮҮВЭР ТЭДГЭЭРИЙН ТАЙЛБАР

М.Хастана¹, Baolidao², С.Цэцэгмаа³, Ш.Болд⁴

¹“Ач” АУИС, ²АШУУИС, ³ЭСХ,

⁴Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

A COLLECTION OF CHINESE MEDICINAL RAW MATERIALS AND PRESCRIPTIONS IN ZORIGT WANG'S “MTHONG BA DGA' BYAD” SUTRA AND THEIR EXPLANATIONS

Khastana.M¹, Baolidao², Tsetsegmaa.S³, Bold.Sh⁴

¹“Ach” Medical University, ² MNUMS, ³Institute of Pharmacology,

⁴Mongolian University of Pharmaceutical Sciences

Abstract

In addition to citing from the old medical scriptures by Indian, Tibetan, and Mongolian medical scholars, “Mthong ba dga' byad” by Jigmeddanzanjamts, also contains a number of prescriptions of Chinese medicine that were widely used in Chinese medical practice at that time. Therefore, crude drugs and prescriptions of Chinese medicine in this book has a great significance, but there are few studies done in the last decades. **Purpose:** To make selection of Chinese herbal medicines and recipes from the book “Mthong ba dga' byad” by Jigmeddanzanjamts and explain them. **Research methods:** *Research methods in ancient textbook, check list, analysis and synthesis methods were used.* **Conclusion:** *It was clarified that in the book “Mthong ba dga' byad” by Jigmeddanzanjamts there are 44 names of herbal medicines and prescriptions of Chinese origin, and some prescriptions are explained. According to these herbal medicines and prescriptions, Mongolian doctors and maarambas used not only Indian Ayurvedic and Tibetan medicines, but also Chinese medicines and prescriptions in their medical care.*

Keywords: “mthong ba dga' byad”, Jigmeddanzanjamts, herbal medicines and prescription

Үндэслэл

Зоригт ван Жигмэдданзанжамц намтар, бүтээлийн судалгааг Монгол Улсаас судлаач Ш.Болд, (2013) Ш.Болд, Б.Жавхлан (2016) нар хийж өөрийн бүтээлдээ тусгайлан дурдсаны зэрэгцээ түүний бүтээлийг монгол бичгээр БНХАУ-ын ӨМӨЗО-д хэвлэжээ^{1,2}. “Үзэгсдийн баясгалан” зохиол нь Энэтхэг, Төвөд,

Монголын анагаахын мэргэдийн анагаах ухааны судар номоос эшлэл авснаас гадна Хятадын анагаах ухааны тухайн үедээ өргөн хэрэглэдэг эмийн жоруудыг багагүй эмхэтгэн авсан байдаг. Тиймээс энэ бүтээлд буй хятад гаралтай эм, эмийн жор ихээхэн сонирхол татдаг ч тусгайлан судалсан судалгааны ажил ховор байна.

Зорилго

Зоригт ван Жигмэдданзанжамцын “Үзэгсдийн баясгалан” анагаах ухааны судар дахь хятад гаралтай эмийн түүхий эд, жорын түүвэр хийж тэдгээрийг тайлбарлах.

Судалгааны арга

1. Эх бичиг судлалын арга
2. Магадлан жагсаах арга
3. Анализ, синтезийн аргыг тус тус хэрэглэв.

Үр дүн

Зоригт ван Жигмэдданзанжамцын “Үзэгсдийн баясгалан” зохиолд³ Монголын уламжлалт анагаах ухааны онол, эмчилгээний судлалд шинчлэл хийсэн, ихээхэн үнэ цэнэтэй бүтээл юм. Тухайлбал үндсэн өвчнийг ялган эмчлэх, өвчний ангилал, бариа заслын судлал гэсэн цоо шинэ ойлголтыг тодруулан гаргасан байдаг^{4,5}. Түүнчлэн Хятад эмнэлэгт хэрэглэдэг эмийн жоруудыг эмхэтгэн өөрийн бүтээлдээ оруулсан бөгөөд лин буюу дан жорыг хятад эмнэлгээс олж аваарай гэхчлэн дурдсан байдаг. Бид судалгааны явцад тус номонд буй хятад анагаах ухааны дан эм, эм найрлагыг түүж жагсаан тайлбар хийлээ.

- Хятад буурцаг

Шүдийг ургуулж үйлдэнэ.

- Нүдний өвчинд хэрэглэх жор

Нүдний өвчнийг ерөнхийд нь Төмрийн талх-5 тан, Дээд-6, Салжэд-30-ыг шүтүүлвээс сайн. Нүдэнд цагаа унасанд хятадын өдөн сүвт цагаан эм болон хятадын лонхтой цагаан эм маш сайн болой. Нүдний хараа муудсанд харааг тодруулагч салжэдыг шүтүүл. Цус, шараас болсон нүдний өвчинд эм тавьж, нүд угаадаг хятад эмээр угаа. Нүдэнд халуун хямарч загатнах аваас зааны сүү хэмээх хятад эмийг түрхэж, Танчэн-25-ын дээр качэ гүргэмийг нэмэрлэж бүрээд тунгалаг шүүсийг нь дусааваас тустай.

- **Хятад хүний үсний хярвас**, цүргар (цагаан байван), цалыг (тунсаа) цагаан балтай найруулж түрх. Өвчний халууны хүч нь их бол Гарьд-5 тэргүүтэн нян, хижгийн ерөнхий эмээр застугай.

- Шүдний өвчинд хэрэглэх жор

Шүдний өвчинд шүдний өвчний үрэл, алтан үрэл хэмээх хятад эмийг шүдний завсарт нь зуулга.

- Хоолой хаагдахад хэрэглэх жор

Хоолой хаагдахад нянгийн ерөнхий эмүүдийг уулгах буюу хятад эм **Бин фэн сан** хийгээд **Мэй хуа диян шэ дан-г** өгнө. Хоолойн хөндийд хотгор гүдгэр нүх гарч яртахад Хоолой-4, Чулуун шунх-6, Улаан зос-6 зэргийг хоолойд үлээтүгэй. Цалгод нэг хувийг уулгах буюу Сэца дэвстай найруулж нүхтэй гуурсаар татуул.

- Нян чихиха

Газрын эзэн, лус нян хилэгнэснээр муу цус, шар усыг хийгээр хуйлруулан, хамт төрсөн хорхой хийгээд нян хижиг хавсарч, мах, яс, судалд барилдаж, чихиха өвчинг үүсгэмой. Чихиха өвчний бэлгэ чанар нь: чихиха хаана гарваас тэнд нь хавдмой, хавдар нь чийрэг бөгөөд халуурах, төмөр хадаас хадсан мэт нийтдээ өвдөж, нян халууны шинж ихэд илэрмой. Үүнийг эмээр туршиж шинжлэх аргаар шинжилж таниад боомыг засах бүлэгт үзүүлсэн засах аргаар засаж, архины шаарын дэвтээлэг, таван рашааны дэвтээлэгт тус тусын нэмэр эмийг тавьж дэвтээтүгэй. Яранд нь **хятад эм Сэн жи сан-г** хуурайгаар тавьж өг.

- Гэдэсний хатгалга

Гэдэсний хатгалга бол нян халуун элгэнд бууснаар элэгний цус доош нэвчирч гэдэс нь хатгуулан өвдөж, суулгаж бөөлжмой. Таван цулын суулгалт бол эвэршээл хатгалга нь их, цустай ус мэтээр суулга.

Зургаан савын суулгалт бол суулгах үеийн эвэршээл хатгалга нь бага шиг бөгөөд суулгын өнгө нь улбар шар, өнгөр язмагтай, нян халууны ерөнхий шинжийг үзүүлмой. Индра-4 тан, Барагшин-13, Догшин-23-ыг **нян халууныг арилгагч хятад эмүүдтэй** уулга.

- Хүйтэн яр

Ус шүүрэх хүйтэн ярын аймагт нясуу, үхэр нясуу зэрэг нэртэй, нэргүй олон зүйл байдгаас их хавдаж, их эвэршээлэгч ярыг Шинца-5 тангаар угааж эвэршээлийг нь нугал. Хүйтэн ярд Ландэг-8-ыг дотроос уулга. Давирхай-4-ийг цацаж, түрхлэгийн хар эмийг түрх. Нясуу, үхэр нясууд нарим будааг чанаад шавш. Жаца хууцэн тосонд зуурч түрхмой. Гүгэл хийгээд давсэнгийн тангаар угаамой. Өгөр гарсан шарханд бух гөрөөсний зүрхийг талхдаж тавиад гахайн өөхийг түрх. Салтаанаас нь ус шүүрч, хошногоноос хүйтэн хөлс дааварласан өвчинд: Дожа, Жүган 2-ыг талхдаад цацаж өг. Вабру-ын танг уулга. Арьс, хөрс нь илжирч загатнаваас, Хар шүдагийн шүүсээр угааж, Жамц-5-ыг нягт талхдан дээр нь цацмой. **Хятад эм Санжисан-г** тавибаас сайн болой.

- **Хятад газрын тэмбүү яр хүрэлцэхүүний хор** нь эрэгтэй, эмэгтэйн бэлгэст, ор дэвсгэрт, уур туссан буюу хүрэлцсэнээр хавдаж түгээд олширмой. Гүвдрүү нь цайвар сэвх бөгөөд загатнаж, маажлахыг дурламой. Махны өнгө нь улаан хүрэн болж, яр нь доошоо идэгдэн хонхойж, маажсанаас болоод өгөр, шүүс үүсэн гармой. Яр нь түгсэнээс эвэршээл хатгалга үүсэн, толгой, бие нь хүндрэн, эрхтний мэдрэл нь хаагдаж, эцэстээ үс хөмсөг нь зулгармой. Царай өнгө нь гоо үзэсгэлэнгүй болж, нүдэнд нь ус эргэж, удах тусмаа бүх биед нь түгмой. Найруулсан хор хэмээгч бол **хятад ёсны** элдэв зүйлийн зайгаар найруулсныг хэлэх боловч, үүнд бона, танпромыг ганц ганцааранг дотор ууснаар хордсон мэтийг хэлмой.

- **Нярайлж ядахад** Бөхөнгийн эвэр-4, Хярвас үнс-5-ын тан, Бойгар-4-ийг өгөх бөгөөд **хятад эм дэ мин дан**, Мөнгөн ус-6, Хүй бай тан, Зулбадас-3 танг өгнө.

- **Ясхэсэгчилэн хугарваас** махыг нь гадагш татаж, гарын үзүүрээрээ тэмтэрч шинжлэхэд шар шар хэмээн дуугарч байгаа газарт дээр доороос нь барьж эвэнд нь оруулаад, махыг нь завсарт нь хавчуулахгүйгээр дээрхтэй адил ороож бэхлээд, боловсруулсан арьсыг зөөлөртөл элдэж 2 хуруу хэртэй зайтай тавьж, үзүүрт нь нүх гаргаж, нарийхан мод оруулж тогтоож тавь. Тэгээд Ба лэ сан, Чэ лэ сан хэмээх **хятад эм ба Нэнбоюүндүн-6 (Ерөндөг зоос-6)** уулга.

- **Өдөн сүвт цагаан эм ба лонхтой цагаан эм 2 бол хятад эмийн жор** бөлгөө.

- **Хятад эм Ян шүй дин, Алтан үрэл зэрэг хятад ёсны** найрлагыг олж хэрэглэвээс чадал нь их сайн болой.

- Хоолойд **хятад эм Вин пэн сан** сайн бөгөөд найрлагыг нь хятад жороос олж үзээрэй.

- **Лин вү юүи дан-ны жорыг хятад эмнэлгээс олж аваарай.**

- **Саяа-ын найрлага үүнийг хятад эмийн жороос олж авагтун.**

- **Сэн жи сан хэмээх хятад эмийн жороос олж авагтун.**

- Бойгар-4

- Бойгар 1 цэн, Лиши 5 пун, Хүдрийн заар 5 пун, 15 буюу шинийн 8-нд алсан туулайн тархинд нухаж үрэлдээд цалгодаар өнгөлж гадарлаад, эмэгтэйгээс далдуур (элгэвч) сайтар буцалгаж өгвөөс, сааталгүй нярайлах болой. **Ди мин хан гэдэг хятад эмийг** хэрэглэвээс сайн.

- Мөнгөн ус-6

Мөнгөн ус 1 цэн, Хүхэр 1 цэн 5 пун, Арүр 3 цэн, Боннаг 1 цэн, Тарна 4 цэн (тараг, айраг, үнээний шээсэнд дэвтээнэ), Данрог 4 цэн эдгээрийг найруулж, үрэл буюу талхны аль зохистойгоор өгвөөс цус бүрэлдсэн, хий бүрэлдсэн бэрх төрөлт ба хойдох саатсаныг 10 сар болсон ч гаргаж чадна. Гүй бай тан бас магад гаргаж чадна. **Гүй бай танг бас хятад** эмийн жороос олж авагтун гэсэн байдаг⁵.

Бид судалгааны явцад хятад гаралтай дараах дан эм, эмийн жорын нэрийг олж тогтоов.

1. Алтан үрэл зэрэг хятад ёсны найрлага
2. Алтан үрэл хэмээх хятад эм
3. Ба лэ сан
4. Ба бау сан 八宝散
5. Боомыг засах бүлэгт үзүүлсэн Хятад эм
6. Гүй бай танг бас хятад эм
7. Ди мин хан гэдэг хятад эм
8. Жаман-3 хятад эм
9. Зааны сүү хэмээх хятад эм
10. Ли дү ван
11. Лин вү юүи дан-ны жорыг хятад эмнэлгээс олох.
12. Линвиюүдан
13. Лон вү юү дан
14. Лонхтой цагаан эм бол хятад эм
15. Мэй хуа диян шэ дан
16. Найруулсан хор (Хятад ёсны элдэв зүйлийн зайгаар найруулсныг хэлнэ)
17. Нянь халууныг арилгагч хятад эм
18. Өдөн сүвт цагаан эм
19. Пай лүн до мин дан
20. Сан хон воү лү ван
21. Са яа хэмээх цанх өвчнийг засах хятад эм
22. Саяа-ын найрлага нь хятад эмийн жор
23. Сэн жи сан хэмээх хятад эмийн жор
24. Хоолойд хятад эм Вин пэн сан
25. Хятад буурцаг
26. Хятад газрын тэмбүү яр хүрэлцэхүүний хор
27. Хятад хүний үсний хярвас
28. Хятад эм алтан үрэл
29. Хятад эм ба Нэнбоюүндүн-6 (Ерөндөг зоос-6)
30. Хятад эм Бин фэн сан
31. Хятад эм Дэ мин дан
32. Хятад эм жин зү сан
33. Хятад эм Санжисан
34. Хятад эм Сэн жи сан
35. Хятад эм Ян шүй дин
36. Хятадын нүд шарлах өвчин
37. Хятадын өдөн сүвт цагаан эм
38. Цагаан шунх-3 хятадын мэргэдийн жор
39. Цон түн нянь бо зоос
40. Цэнья үрэл
41. Чи ли сан
42. Чүн ган түн бо

“Үзэгсдийн баясгалан” зохиол бичигдсэн хэлбэр, агуулгын талаасаа бусад номоос ялгарах онцлогтой бүтээл гэж үзэхээр байдаг. Энэ нь зохиогчийн сэтгэлгээний өргөн цар, хүрээ дадлага, туршлагатай ихээхэн холбоотой. Ер нь аливаа өвчнийг бүхэл цогц үзлийн талаас нь илүүтэй авч үздэг байсан нь харагддаг.

Дүгнэлт

Жигмэдданзанжамцын “Үзэгсдийн баясгалан” сударт хятад гаралтай эмийн түүхий эд, жорын нэр 42 байгааг тодруулан зарим жорын тайлбарыг хийлээ.

Эдгээр эм, эмийн жороос харахад монгол эмч, маарамба нар хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээнд зөвхөн Энэтхэгийн Аюурвед, Төвд анагаах ухааны эмүүдийг хэрэглэхээс гадна Хятад анагаах ухааны эм, эмийн жорыг өргөн хэрэглэж байжээ.

Ном зүй

1. Болд.Ш. Монголын анагаах ухааны түүх. Дөрөвдүгээр боть. УБ, 2013
2. Болд Ш, Б.Жавхлан. “Хүннүгээс XXI зууны Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш, бариач нарын цадиг, бүтээлийн ойллого” УБ, 2016
3. Жигмэдданзанжамц. “Үзэгсдийн баясгалан” (Төвөд хэлнээс орчуулсан

Отгонбилэг, Дуван Гомбожав). Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо. 2016

4. Bold Sh. Development of Traditional Mongolian medicine Clarified by the Source Materials. Dissertation for Doctor of Medical Science. Ulaanbaatar: 2006.
5. Болд.Ш. Монголын анагаах ухааны түүх. Дөрөвдүгээр боть. УБ, 2013

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор, дэд профессор
Л.Уламбаяр*